

## VII. Түүхэн тэмдэглэл, шүүмж

### НЭРТ ТҮҮХЧ Г.В.ВЕРНАДСКИЙ: АМЬДРАЛ, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ҮЗЭЛ САНАА (Түүхэн тэмдэглэл)

Ж.Болдбаатар\*

С.Одхүү\*

\*Монгол улсын их сургууль, Нийгмийн шинжлэх ухааны сургууль, Түүхийн тэнхим.

\*Монгол улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар.

Георгий Владимирович Вернадский (1887-1973) бол хилийн чанад дахь Оросын гарамгай эрдэмтэн, Евразийн үзлийг үндэслэгчдийн нэг, соёл судлаач, нэрт түүхч мөн. Тэрбээр Москвагийн их сургуулийн профессор, Оросын нэрт эрдэмтэн В.И.Вернадскийн хүү бөгөөд Петербургт эцэг, эхийн насан идэрт хувь тохион мэндэлж хүүхэд, бага насаа Москва хотноо өнгөрөөж, 1905 онд гимнази дүүргээд Москвагийн их сургуулийн түүх, хэл шинжлэлийн салбарт элсэн оржээ. Гэвч энэ үеэс Орос оронд хувьсгалт хөдлөлгөөн өрнөж, тус их сургуулийн хичээл хаагдахад хүрснээс Г.В.Вернадский Германыг зорьжээ. 1906 онд Берлин ба Фрейбург хотуудын их сургуульд нэртэй том профессоруудын номын хэлээс үлэмжийг сонсож, Риккертын үзлийн нөлөөнд хүчтэй автан, түүний билгийн мэлмий улам улам нээгдэж байлаа.

Риккертын үзлээс Г.В.Вернадскийн онцолж сонирхсон асуудал нь түүхийн танин мэдэхүйн бие даасан, тусгаар шинжийн тухай өвөрмөц содон санаа юм. Виндельбандын үзлийг залгамжлагч Риккөртийнхээр нийгэм, соёлын болон байгалийн тухай шинжлэх ухаанууд хоорондоо зарчмын ялгаатай, тэр ялгаа нь танин мэдэхүйн үйл явцад хандах аргад байдаг тухай үндэслэлийг талархан дэмжиж, анхааран судлахыг уриалж байв.

1906 оны хур отголж, цас бударч эхэлсэн намар цагт Г.В.Вернадский Москва хотноо буцан иржээ. Тэрээр анхандаа улс төрийн амьдралаас хол хөндий байсан боловч төдөлгүй ардын эрх чөлөөний /кадетчуудын/ намын оюутны жигүүрт элсэн идэвхтэй гишүүн нь болов. Ташрамд, түүний эцэг Үндсэн хуулийн ардчилсан үзэлтнүүдийн намын Төв Хорооны гишүүнээр сонгогдон, тус намын нэг нөлөө бүхий удирдагч болсон аж. Насан туршдаа Георгий Владимирович либерал ардчилсан үзэлтэн байж, нийгмийн амьдралд хүчирхийлэл хэрэглэхийг эсэргүүцэж, дарангуйллын үзэл санааг үл хүлээн зөвшөөрч байлаа.

Г.В.Вернадский бүх цаг зав, хамаг анхаарлаа түүхийн шинжлэх ухаанд зориулж, судалгааны ажлыг даацтай хийж байлаа. Москвагийн их сургуульд байхдаа Ключевский, Готье, Виппер, Кизеветтер, Петрушевский, Любавский, Богословский зэрэг нэрт түүхчдийн лекцийг шимтэн сонсож, тэднээс суралцаж, эрдмийн нөөлөгт нь багтан үлгэр дууриал авч байлаа. Суралцахын зэрэгцээ тэрээр Дорогомиловын ажилчдын курст болон Мытицид амралтын өдрүүдэд цуглардаг сүсэгтнүүдэд түүх, онолын хичээл зааж байв.

Оюутан ахуй цагтаа Прага хотод болсон славян судлаачдын олон улсын бага хуралд оролцон, хожим Чехословак Улсын Ерөнхийлөгч болсон Масаиктай дотно танилцаж нөхөрлөжээ. Тэрээр оюутан байхаасаа цаг мөч бүр танин мэдэхүйн баяслыг амсч, бясалган эргэцүүлсээр 1910 онд их сургуулиа I зэргийн дипломтой төгсөв. Магистрын зэрэг хамгаалах эрдэм шинжилгээний ажлаа XVI-XVII зуунд Сибирь нутгийг колоничилсан тухай содон, сонин сэдвээр бичихээр төлөвлөж, түүхийн ховор, чухал баримт цуглуулан уйгагүй ажиллаж байв. Гэтэл 1911 онд түүний эцэг В.И.Вернадский Тамбов мужид байсан өөрийн эзэмшил газрын болон мужийн хуралд төлөөлөн оролцох эрхээ түүнд шилжүүлснээс

судалгааны ажил нь түр саатжээ. 1913-1914 онд бичсэн өгүүлэлүүддээ цаашид судалгаа хийхээр зорьж буй Орос дахь түүхэн цаг хугацаа, орон зайн харилцан хамаарлын асуудлыг хөндөн тавьж байлаа.

Энэхүү асуудал дэвшүүлсэн өгүүлэл нь Оросын үндэсний өвөрмөц онцлогийг тод тусгасан түүхийн тооллын шинэ үеийг нээсэн гэж хэлж болно. Нээлтийн гол санаа нь орон зай тогтмол байхад нийгмийн үзэгдэл цаг хугацаанд өөрчлөгдөнө, цаг хугацаа тогтмол байхад нийгмийн үзэгдэл орон зайн хил хязгаарыг өөрчлөнө, эдгээр өөрчлөлтийн харьцаа нь хам шүтэлцээтэй, харилцан тэнцвэртэй байдаг болоход оршино. Оростой адил төстэй асар том газар нутагтай улс гүрэнд энэ санаа таарч тохирдог төдийгүй, Г.В.Вернадскийн итгэлтэй нотолсноор, тухайн орны түүхийн философийг тодорхойлдог ажээ. Г.В.Вернадскийн дэвшүүлсэн эл содон санаа Евразийн үзлийн нэг чухал тулгуур үндэслэл болсон юм. Дашрамд, Евразийн үзлийн үндсэн ойлголт, зарчмуудыг томъёолж, онолын хувьд боловсруулж хөгжүүлсэн П.Н.Савицкийн дэвшүүлсэн "орон зайн хөгжил" хэмээх ухагдахуунд тэрээр чухал ач холбогдол өгч талархан дэмжиж байв.

1911 онд өрнөсөн оюутны хөөрөн дэвэрсэн хөдөлгөөний дараа ардчилсан үзэлт багш Кизевөтер, Петрушевский нар Москвагийн их сургуулиас явцгааж, Вернадскийнхан ч уугуул Петербург хотдоо эргэж иржээ. 1913 онд Георгий эцэг, эхийнхээ араас ирж, 1914 оны хавар Петербург хотын их сургуулийн Оросын түүхийн тэнхимд доцент болж, гурван жилийн дараа "II Екатерины үеийн Оросын массончууд" сэдвээр магистрын зэргийг амжилттай хамгаалжээ.

Түүний эрдэм шинжилгээний ажлын удирдагч нь "Москвагийн түүхийн сургууль"-ийн захирал нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн лидер, нэрт эрдэмтэн В.О.Ключевский, "Петербургийн салбар"-ын тэргүүн С.Ф.Платонов нар байсан нь том түүхчдийн анхаарлын төвд өртөж байсны гэрч мөн.

Тэрээр энэ үеэс Америкийн түүхч Ф.Голдер, Р.Лорд нартай дотно танилцжээ. Хожим тэдний тусламжтайгаар Америкийн эрдэм шинжилгээний хамтын нийгэмлэгийн гишүүн болсон билээ. Төдөлгүй Г.В.Вернадский шинээр байгуулагдсан Перьм хотын их сургуулийн Оросын түүхийн тэнхимийн эрхлэгч боллоо. Энэ үедээ тэрбээр эрдэмтэн Н.И.Новиковын намтрыг хэвлүүлж, "Нийгэм түүхийн мэдлэг, гүн ухааны нийгэмлэг"-ийг үүсгэн байгуулах санаачилга гарган, зохион байгуулалт, хөгжилд жинтэй хувь нэмрээ оруулсан юм. Тус нийгэмлэгээс эрхлэн гаргасан эрдэм шинжилгээний цуврал бүтээлүүдийн анхны эмхтгэлийг өөрөө хянан нягталжээ.

Г.В.Вернадский оюутан үеэсээ массончуудаас гадна сонирхон судалж байсан сэдэв нь Оросын амьдрал, түүхэнд Дорнын үзүүлсэн нөлөө, Орос Дорно дахины харилцааны асуудал юм. Залуу судлаач энэ сэдвээр хэд хэдэн сонирхолтой, даацтай өгүүлэл бичсэн нь тухайн үедээ түүхчдийн сонирхлыг татаж, шуугиан дэгдээж байжээ. Цаашдаа чухамхүү энэ сэдэв түүний эрдэм шинжилгээний ажлын гол агуулга, тэргүүлэх чиглэл нь болсон юм.

1918 оны I сард Пермь хотод Зөвлөлт Засаг тогтсон нь либерал ардчилсан үзэлт, эрдэмтэн Г.В.Вернадскийн эрдэм шинжилгээ, сурган хүмүүжүүлэх үр бүтээлтэй үйл ажиллагаанд хүндрэл бэрхшээл учрууллаа. Хүчирхийллийн үзэл санааг хүлээн зөвшөөрдөггүй, ардчилсан үзэлт Г.В.Вернадский Октябрийн хувьсгалт эргэлтэд шүүмжлэлтэй хандсан, Түр Засгийн газрын гишүүн Милюковын намтрыг хэвлэн гаргасан, ажилчин бус сэхээтэн гаралтай, кадет намын гишүүн болсон, шашны зүтгэлтнүүдтэй дотно харилцаатай байсан, оюутнуудад ятгалга хийсэн зэрэг шалтгаан, хардлагаар улс төрийн хувьд үл бүтэх этгээдэд тооцогдох болжээ. Улмаар шинэ Засгийн газраас түүнийг баривчлах шийдвэр гаргасныг итгэлт нөхдийн тусламжтайгаар мэдээд, Перьм хотоос аргагүйн эрхэнд дүрвэн явж, Симферополь хотод ирэв. Симферопольд багшлахын зэрэгцээ эрдэм шинжилгээний ажилдаа идэвхийлж 1920 оны IX

сараас гегерал Врангелийн засаг захиргаанд хэвлэл-мэдээллийн тасгийн даргаар хавсран ажиллажээ. Зөвлөлт засаг тогтсоноор үзэл санаандаа үнэнч үлдэхийн тулд хилийн чинадад дүрвэн гарахаас аргагүйд хүрсэн байна. Улмаар 1920 онд Константинополоор дамжин Афин хотод хүрэлцэн очив. 1922 оны II сараас Г.В.Вернадский Прага хотын Карловын их сургуулийн хууль зүйн факультетад Оросын эрх зүйн тэнхимд профессор болжээ. Тэрээр Оросын соёл, Оросын эрх зүйн түүх, онол, төр нь соёл иргнэшлийн өвөрмөц үзэгдэл болох тухай зэрэг чухал асуудалд голлон анхаарч, сонирхолтой цуврал лекцийг уншиж байлаа.

Прага хотод ирсэнээс хойш Г.В.Вернадский эрдэм судалгааны ажилд бүх хүчээ сорьж, томоохон эрдэмтэн судлаач болж төлөвших зам орсон юм. Чухамхүү энэ үедээ соёл, урлаг судлаач, дундад зууны болон Византийн үеийн түүх, соёлыг дагнан судлагч нэрт эрдэмтэн, академич Н.П.Кондаковтой ойртон танилцаж, дотносон нөхөрлөжээ. Тал нутгийн, Византийн болон славяны соёлууд еер хоорондоо салшгүй холбоотой болох тухай түүний үзлийг Г.В.Вернадский хүлээн зөвшөөрч, Н.П.Кондаковын итгэлт шавь, үзэл бодлыг нь тууштай үргэлжлүүлэгч болжээ. 1925 онд Н.П.Кондаковыг нас барсны дараа багшийнхаа дурсгалд нь зориулан түүний нэрэмжит онолын семинарыг үүсгэн байгуулж, тогтмол явуулах болжээ. Хожим энэ семинарын буурин дээр түүний санаачилга, удирдлаган дор Прага хотын Н.П.Кондаковын нэрэмжит институт үүсэн байгуулагдсан түүхтэй. Энэ үеэс П.Н.Савицкийтай ойртон дотносож, үр бүтээлтэй хамтран ажиллаж, евразийн үзлийг дэмжигчдийн хөдөлгөөнд хамрагдах боллоо. Гэхдээ евразийн үзлээс улс төрийн үзэл баримтлалыг нь хүлээн зөвшөөрдөггүй байжээ.

Евразийн үзлийн түүхийн хэсгийг томъёолон боловсруулах амаргүй үүргийг санаачилгаараа өөртөө авч, уйгагүй ажиллан “Оросын түүхийн зураглал” /1927 он. Прага хот/ “VI зуунаас эдүгээ хүртэлх үеийн евразийн түүхийн туршлага” /1934 он. Берлин хот/, “Оросын соёлын бүрдлүүд” /1938 он. Берлин хот/ зэрэг судалгааны томоохон бүтээлүүдийг туурвижээ. Эдгээр бүтээлүүдэд нь Евразийн үзлийн үндсэн ойлголт, гол санаанууд хурц тод, бүрэн төгс тусгалаа олсон гэж түүхчид, судлаачид санаа нэгтэй хүлээн зөвшөөрдөг. Бас Г.В.Вернадский анхаарлаа онцгойлон төвлөрүүлж, гүнзгийрүүлэн судалж байсан зарим асуудлуудыг авч үзвээс:

1. Бүр Ключевскийн үеэс хөндөгдөн, судлаачдын хүрээнд хүлээн зөвшөөрөгдсөн үзэл болох ой болон тал хээрийн харьцаа, харилцан хамаарал нь оросын нийгэм-соёлын түүхэнд байгалийн шийдвэрлэгч хүчин зүйл болох тухай; түүнчлэн Оросын амьдралд суурин болон нүүдлийн соёл иргэншил аль аль нь хүчтэй нөлөөлсөн тухай санааг дэвшүүлж, батлахыг оролджээ.

2. Орос дахь “христосжсон татарчуудын” өвөрмөц үзэгдэл, түүнд тусгалаа олсон Византийн болон Турк, Монголчуудын соёлын нэгдэл /Н.Трубецкийн дэвшүүлсэн энэ санааг тэрээр талархан дэмжиж байв/, гэхдээ түүний ойлгож, номлож байснаар тэр үеийн соёлжсон харилцаанд турк, монголын хүчин зүйл хүчтэй нөлөөлснийг төрийн үүсэл, зохион байгуулалт, хөгжлийн баримтаар нотлон харуулж чаджээ.

3. Евразийн нийгэм-соёлын түүхэн дэх газарзүйн хамаарал, нөлөө нь өрнөдөөс үүдэлтэй гэсэн үзлээс зайлсхийж, чухамхүү дорно зүгээс, үүр цайж, нар манддаг чиглэлээр тодорхойлох нь зүйтэй гэж үзсэн байна.

Г.В.Вернадский Оросын түүхэнд монголчуудын дарангуйлал сөргөөр нөлөөлсөн гэж бичиж байсан уламжлалт хандлага, өрөөсгөл үзлийг хүлээн зөвшөөрөөгүйгээр барахгүй няцааж үгүйсгэсэн юм. Оросын амьдрал, соёлд “монголчуудын дарангуйлал” гэгч голлон эерэг нөлөө үзүүлж, монголчууд оросыг эзэлснээр дэлхийн эзэнт гүрний бүрэлдхүүн хэсэг болгож, Оросыг дэлхий дахины анхаарал, тогтолцоонд оруулж чадсаныг онцлон тэмдэглэсэн байна.



Г.В.Вернадскийн томъёолсон бас нэг чухал санаа бол төр ёс үүсэх нэгдмэл үйл явц тодорхой хэмнэл, мөчлөгтэй байсан, энэ үйл явц чухамхүү евразийн түүхэнд үзэгдсэн болохыг нотлон тодорхойлсонд оршино. Евразийн уудам орон зайд их гүрэн ЗХУ бий болсон ч Скифийн гүрэн, Монголын эзэнт гүрэн улстай адил тодорхой цаг хугацааны дараа хүч нь сулран задарсан нь түүхэн үйл явц тодорхой мөчлөгтэй байдаг тухай түүний санааг баталсан мэт санагдана. Евразийн түүх тодорхой мөчлөгтэй болохоос гадна дотоод бүтэц, бүрэлдэхүүний хувьд ч залгамж чанартай бас илрүүлжээ. Тухайлбал: бат тогтвортой төрт ёс, хүчирхэг дэг журамтай Засгийн газар, уян хатан нийгмийн бүтэц бүхий цэргийн эзэнт гүрэн, ард түмэнд тулгуурласан нэг хүний дарангуйлал зэрэг төвлөрсөн шинжүүдийг нэрлэжээ.

Энд дурдсан зарчим, шинжүүд алдагдсан тохиолдолд евразийн нэгдмэл төр ёс хүчирхэг байдлаа алдаж задран унах, мөхөл сүйрлийн ирмэгт хүрч байсныг баримтаар дүрслэн үзүүлсэн байдаг.

Нэгдмэл, хүчирхэг чанараа хадгалж хамгаалах байдлыг дотоод талаас нь авч үзвэл ард түмэн оршин тогтнол, хөгжлийн төлөвөө өөрсдөө ухамсарлан ойлгох, хүч бололцоогоо дайчлан тэмцэх явдал ажээ.

Г.В.Вернадский бүхий л зохиол бүтээлдээ өөрийн сонгосон арга зүй зарчимдаа үнэнч байж, Еврази нь түүх-соёлын өвөрмөц үзэгдэл болох тухай үзэл баримтлалаа тууштай хөгжүүлж чадсан юм.

1920-иод оны эцсээр Орос цагаачдын байдал Чехословакад нэн хүндэрсэн байна. Дэлхийн хямралаас болж дотоод байдал нь хүндэрч, хөрөнгө оруулалт багасаж, хилийн чанад-Прага хотноо ажиллаж байсан оросын шинжлэх ухаан, соёл боловсрол, сургалтын байгууллагууд хаагдан, орос оюутны тоо эрс цөөрч, оросын олон эрдэмтэн, зохиолчид Прагаас дүрвэн явцгаах болов. 1927 онд Г.В.Вернадский аргагүйн эрхэнд Чехословак улсаас явж, Америкийн түүхч Голдөр, Оросын эртний түүх-археологийн нэрт эрдэмтэн М.И.Ростовцев нарын зөвлөмж дэмжлэгээр АНУ-ын Йельскийн их сургуульд профессороор уригдан 1956 онд тэтгэвэрт гартлаа тэндээ ажиллажээ. Дараа нь насан өөд болтлоо АНУ-ын Нью-Хейвен хотод амьдарсан байна. 1931 оноос Йельск, Харвард, Колумб, Чикагогийн их сургуулиудад багшталж АНУ, Европт болсон олон улсын эрдэм шинжилгээний хурлуудад оролцож, шинэлэг санаа бүхий сонирхолтой илтгэл тавьдаг байжээ.

"Оросын түүх: Киевийн ванлиг, эзэн хааны ноёрхлын болон зөвлөлт засгийн үе дэх эдийн засгийг удирдах асуудал" /1933 он, Америкийн түүхчдийн холбооны их хурал/, "Орос дахь феодализм" /1938 он. Цюрих хотын түүхчдийн олон улсын бага хурал/, "Чингис хааны Их засаг хуулийн бүтэц" /Брюссель.Дорно дахины судлаачдын олон улсын XX бага хурал/ зэрэг асуудлаар даацтай судалгаа явуулж, сонирхолтой илтгэл тавьж байсан нь шуугиан дэгдээж, анхаарал татаж байлаа. "Оросын түүх" олон боть суурь бүтээлийг туурвисан нь Г.В.Вернадскийн түүхийн шинжлэх ухаанд оруулсан том гавъяа юм. Хамтран ажиллаж байсан профессор Карпович 1959 онд нас барснаар энэ номоо дуусгаж чадаагүй ч Г.В.Вернадский өөрийн хариуцсан хэсгүүдийг бичиж дуусгажээ.

Эрдэмтэн Г.В.Вернадскийг 1973 онд 86 насандаа нас барсны дараа түүний америк шавь нар 6 дахь ботийг хэвлэлд бэлтгэн нийтийн хүртээл болгожээ.

Америкийн славян судлалыг хөгжүүлэхэд Г.В.Вернадскийн оруулсан жинтэй хувь нэмрийг Америкийн шинжлэх ухааны нийгэмлэг өндрөөр үнэлж, түүнийг дундад зууны үеийн Америкийг судлах Академийн жинхэнэ гишүүнээр сонгож, 1956 онд Йельскийн их сургуулийн түүхийн хүндэт профессор цол, 1958 онд Колумбийн их сургуулийн нийгмийн шинжлэх ухааны хүндэт доктор цолыг тус тус хүртээжээ. 1965 онд Славян судлалын америкийн холбоо Г.В.Вернадскийг холбооныхоо байнгын хүндэт ерөнхийлөгчөөр насан туршид нь сонгож, 1970 онд холбооныхоо хамгийн эрхэм дээд шагналаар шагнажээ. АНУ-

ын эрдэм шинжилгээний байгууллага, эрдэм судлалын ажилтнууд Г.В.Вернадскийн 70, 80 жилийн ойг өргөнөөр нэн хүндэтгэлтэй тэмдэглэсэн байна. Амьдралынхаа сүүлчийн өдрийг хүртэл Г.В.Вернадский хөдөлмөрлөж, Христосын шашны тэргүүн хамба Никонтой захидлаар байнга харилцаж, түүний тухай өгүүлүүд хэвлүүлж, намтрыг нь бичиж эхэлсний зэрэгцээ өөрийн дурсамжаа тэрлэж байжээ.

Ертөнцийн мөнх бусыг үзсэнийх нь дараа түүний шавь нар, үзэл бодлыг үргэлжлүүлэгчдээс гаргасан эмгэнэлийн бичигт Г.В.Вернадский АНУ-д бараг 50 жил ажиллахдаа түүхийн хүчирхэг дэг сургууль үүсгэн байгуулж, хөл дээр нь босгосныг онцлон дурдаад, оросын түүхийн шинжлэх ухаанд биеэ даасан бүтээлч үеийг бий болгож төлөөлж ирсэн нэрт түүхчдийн хамгийн сүүлчийн том эрдэмтэн байлаа гэдгийг тусгайлан тэмдэглэжээ.

Коммунизм сүйрсний дараа Орос оронд үндэсний ухамсар сэргэж Евразийн үзлийг сонирхох болсонтой холбогдуулан сүүлийн жилүүдэд л Г.В.Вернадскийг биеэ даасан сэтгэгч, өвөрмөц эрдэмтэн, нэрт түүхч, соёл судлаач болохынх нь хувьд хүлээн зөвшөөрч, гавъяаг зүй ёсоор үнэлэн, анхаарлаа зохих ёсоор хандуулан идэвхтэй, эрчимтэй судлах боллоо.

Өнгөрсөн онд ОХУ-ын "Аграф" ном хэвлэлийн газраас "Шинэ түүх" цувралаар Г.В.Вернадскийн "Оросын түүх" хэмээх алдарт бүтээлийг 5 боть, 6 дэвтэрээр хэвлэн гаргасан нь оросуудын талархлыг хүлээж, нийтийн хүртээл болж шүүн хэлэлцэгдэж байгаа юм байна.

Г.В.Вернадский анх 1927 онд Америкийн их дээд сургуулийн оюутнуудад зориулж "Оросын түүх" сурах бичиг хэвлүүлжээ. Энэ бүтээл өрнөдийн орнуудад хамгийн сонгодог сурах бичигт тооцогдон, Америкийн сургуулиудад олон жил хэрэглэгдсэн энэ номоо нэмэлт засвар оруулж, шинэ баримт материалуудаар баяжуулан 1969 онд шинэчлэн хэвлэгдсэнтэй нь оросын уншигчид бас одоо л танилцаж буй ажээ. Оросын түүхийг улс төрийн, шашин сүм хийдийн, урлаг утга зохиолын хөгжлийн түүхтэй амьд холбоо хэлхээнд авч үзсэнээрээ Г.В.Вернадскийн энэ ном анхаарал сонирхол татаж, ач холбогдол, үнэ цэн нь өсч буй бололтой.

"Оросын түүх" сурах бичиг нь адил төстэй түүхийн бусад номуудаас түүхэнд өгсөн үнэлгээний оновчтой байдал, оросыг нэн сонирхож, гүн хүндэтгэлтэй хандсан эерэг хандлага, сэдвээ чөлөөтэй илэрхийлсэн өвөрмөц хэлбэр, агуулга, уншигчдад санаагаа хүргэсэн амьд, ойлгомжтой хэл зэргээр гойд ялгарч байна. Энэхүү сурах бичиг Америкт болон барууны орнуудад нэмж засварлагдан, эрдэмтний өөрийг нь амьд сэрүүн үед 6 удаа хэвлэгдэж байсан бөгөөд орос хэл дээр анх удаа орчуулагдан, эх орон нэгтнүүддээ хүрч байна.

Түүхч Г.В.Вернадскийн туурвисан сүүлчийн ном нь "АНУ дахь Оросын салбар академийн тэмдэглэл" цувралаар /1971-1975/ орос хэл дээр хэвлэгдсэн "Оросын түүх бичлэг" хэмээх том хэмжээний дорвитой бүтээл юм. Энэ бүтээлд Оросын түүх бичлэгийн хөгжлийг XVIII зуунаас эхлэн 1920 оны "Оросын түүхийн шинжлэх ухааны мөхөл"-ийн үе хүртлэх хугацааг хамран авч үзжээ. Энэ даацтай судалгаа нь оросын түүхийн шинжлэх ухаанд энэхүү нэр хүндтэй түүхчийн үлдээсэн үзэл санааны баялаг өв юм.

Номын агуулгыг Нью-Йорк дахь Колумбын их сургуулийн Бахметьевскийн архивт хадгалагддаг, эрдэмтний хувийн өвөөс авсан баримт, тайлбар зэрэг сонирхолтой баримт сэлтээр баяжуулан хэвлэжээ.

Энэхүү өвөрмөц эрдэмтний бас нэг сонирхолтой бүтээл нь 1931 онд АНУ-ын англи хэл дээр анх хэвлэгдсэн "Ленин бол улаан дарангуйлагч мөн" хэмээх гойд содон ном юм. Энэ номонд Орос орны хөгжилд В.И.Лениний гүйцэтгэсэн үүрэг, үзүүлсэн нөлөөний тухайд улс төрийн зорилго, үзэл санаанд автагддаггүй байсан эрдэмтэн Г.В.Вернадский өөрийн бодол дүгнэлтээ тод тусгасан ажээ. Орос хэлээр гарсан энэ ном бас л анх удаагаа хэвлэгдэж байгаа ажээ.

Нэрт түүхт Г.В.Вернадский Монголын түүхийг сонирхон Монголчуудаас Орост үзүүлсэн зэрэг нөлөөг зөвөөр ойлгон, зүй ёсоор үнэлж байсныг онцлон тэмдэглэхэд таатай байна.

Монгол судлалд жинтэй хувь нэмэр оруулсан, бидний сайн мэдэх Ю.Н.Рерих, Л.Н.Гумилев зэрэг монголч эрдэмтэд түүний шавь нар байж үзэл санааг нь тууштай үргэлжлүүлж ирснийг зохиол бүтээл, өв дурсгал нь гэрчилнэ.

Евразийн үзлийг үндэслэгчдийн нэг Г.В.Вернадскийн бичсэн “Орост Монголчуудын үзүүлсэн нөлөө”, “Оросын түүхэн дэх Монголчуудын дарлал” хэмээх сонирхолтой, сургамжтай өгүүллүүдийг бид орчуулан “Монголчууд ба орос” нэрийн дор монгол уншигчиддаа хүргэх гэж байгаагаа хэлье юу.